

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН 2004 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Илтгэгч нь: Ерөнхий шүүгч
Ч.Ганбат

Дээд шүүхийн эрхэм шүүгчид, албан хаагчид аа!

Улирч буй **2004 онд** Монгол Улсын Үндсэн хуулийн дагнасан шүүх байгуулах тухай үзэл баримтлал биеллээ олж, Захиргааны хэргийн шүүх байгуулагдсан явдал нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хууль дээдлэх замаар эрх зүйт төрийг төлөвшүүлж, иргэний ардчилсан нийгэм байгуулах зорилтыг хангахад чиглэсэн түүхэн тэмдэглэлт томоохон үйл явдал боллоо.

“Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай” Монгол Улсын хуулиар 21 аймаг, нийслэл тус бүрт захиргааны хэргийн анхан шатны шүүх, Улсын Дээд шүүхэд захиргааны хэргийн танхим байгуулагдахаар зааж, тэдгээрт ажиллах 76 шүүгчийн орон тоог Улсын Их Хурлын тогтоолоор баталж, шүүгчдийн ихэнх нь эдүгээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар томилогдон ажиллаж байна.

Түүнчлэн “Шүүхийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, Захиргааны хэргийн шүүх болон Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүн таслах үйл ажиллагааны журмыг “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай” хуулиар зохицуулж өгсөн билээ.

2004 онд манай ихэнх шүүгч, ажилтнууд албан үүргээ зохих ёсоор амжилттай биелүүлж байгааг Төр, засгаас өндрөөр үнэлж Монгол Улсын **Ерөнхийлөгчийн зарлигаар** Баян-Өлгий аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Р.Асхабыл, Нийслэлийн шүүхийн шүүгч Ц.Тогоохүү, Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч М.Цэрэнбалжир, Дорнод аймгийн шүүхийн шүүгч Б.Загдхорлоо, Төв аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч Ш.Дуламжав, Хэнтий аймгийн шүүхийн тамгын хэлтсийн дарга А.Очир нарын **6** хүнийг “**Алтан гадас**” одонгоор;

Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгч Х.Алтанцэцэг, Багануур дүүргийн шүүхийн шүүгч Д.Оюунбат, Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгч Д.Батсуурь, Ховд аймгийн шүүхийн шүүгч Б.Дамба, Дээд шүүхийн тамгын газрын дарга Д.Эрдэнэчулуун, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн тамгын хэлтсийн дарга Д.Энхбаатар, Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн туслах бөгөөд нарийн бичгийн дарга Ж.Усны-Эх, Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгчийн туслах бөгөөд нарын бичгийн дарга Баяртогтох нарын **8** хүнийг “**Хөдөлмөрийн хүндэт медаль**”-иар шагнасан билээ.

Түүнчлэн **Шүүхийн Ерөнхий зөвлөлийн тогтоолоор** Дээд шүүхийн шүүгч Д.Тунгалаг, Нийслэлийн шүүхийн шүүгч Л.Даваасүрэн, Дархан-Уул аймгийн шүүхийн шүүгч Б.Нүрзэдмаа, Өмнөговь аймгийн шүүхийн шүүгч Р.Авирмэд, АНУ-ын “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр” төслийн удирдагч Роберт Ла Монт нарын **5** хүнийг “**Шүүхийн тэргүүний ажилтан**” цол, тэмдгээр;

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын захирамжаар Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Р.Жамъянчойжил, хангамжийн асуудал хариуцсан менежер С.Баасанцэрэн, Нийслэлийн шүүхийн шүүгч Ц.Зориг, Дундговь аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Ш.Төмөрбаатар, Баян-Өлгий аймгийн шүүхийн шүүгч Ө.Сауле, Төв аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч Ц.Балжинням, Хан-Уул дүүргийн шүүхийн шүүгч Ц.Батхүү, Дархан-Уул аймгийн шүүхийн Тамгын хэлтсийн дарга Д.Дорж, Архангай аймгийн шүүхийн нягтлан бодогч Б.Алтанчимэг, Дорнод аймгийн шүүхийн нярав Л.Цэрэндулам, Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга П.Ариунбилэг, Нийслэлийн шүүхийн бичээч Ж.Пүрэвням нарын **33** хүн Шүүхийн Ерөнхий зөвлөлийн “**Хүндэт тэмдэг**”-ээр шагнагджээ.

Мөн **Хууль зүй дотоод хэргийн сайдын тушаалаар** Дээд шүүхийн шүүгч М.Дамирансүрэн, Өвөрхангай аймгийн шүүхийн шүүгч С.Дорждавга, Нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн шүүгч Х.Батбаяр нарыг “**Хууль зүйн тэргүүний ажилтан**” цол тэмдгээр, Баян-Өлгий аймгийн шүүхийн шүүгч С.Цэрэндорж, Дээд шүүхийн судалгааны төвийн иргэний шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч Ц.Нарангэрэл нарыг Хууль зүй, дотоод хэргийн яамны “**Хүндэт жуух бичиг**”-ээр тус тус шагнасан байна.

Үүний зэрэгцээ **Гэмт хэрэг үйлдсэн** нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол нь хүчин төгөлдөр болсон Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Чантуугийн Элдэв-Очир, Булган

аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Сүрэнхорын Амар нарыг Монгол Улсын **Ерөнхийлөгчийн зарлигаар** шүүгчийн албан тушаалаас **огцруулж**;

Ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн хувьд Сум дундын шүүхийн **Ерөнхий шүүгчийн** албан тушаалд **тэнцэхгүй** тухай Шүүхийн мэргэшлийн хорооны дүгнэлт гарсан учир Төв аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгч Д.Буянтогтохыг **Ерөнхий шүүгчийн** албан тушаалаас;

Ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн хувьд **шүүгчийн** албан тушаалд тэнцэхгүй тухай Шүүхийн мэргэшлийн хорооны дүгнэлт гарсан тул Увс аймгийн шүүхийн шүүгч Л.Жавзмаа, Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Б.Баттулга, Төв аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч Н.Чулуунжав нарыг шүүгчийн албан тушаалаас **чөлөөлж** Монгол Улсын **Ерөнхийлөгчийн зарлиг** гарсан юм.

Үүнийг өнгөрсөн жилтэй харьцуулахад **огцорсон** шүүгч 7-оор, “шүүгчээр ажиллах боломжгүй” гэсэн дүгнэлт гарч шүүгчийн албан тушаалаас **чөлөөлөгдсөн** шүүгч 4-оор тус тус багассан байна.

2004 онд нийт **57** хүн Дээд шүүх болон аймаг, нийслэлийн, захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд, харин **31** хүн аймаг, сум, сум дунд, дүүргийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилогдсон.

Харин **22** хүн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөний **19** хүн өөр ажил албан тушаалд, томилогдсоны учир, **2** хүн өөрөө хүсэлт гаргасан, **1** хүн тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тул шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдөж, **3** шүүгчийг ажлын шаардлагаар нэг шүүхээс нөгөөд **сэлгүүлэн** ажиллуулахаар Монгол Улсын **Ерөнхийлөгчийн зарлиг** гарсан байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурортой хамтран “**Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаанд холбогдох баримтын төрөлжсөн архивын ажлын заавар**”-ыг батлан хэрэгжүүлж байна.

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн тогтоолоор “**Шүүхийн менежментийг боловсронгуй болгох үзэл баримтлал**”-ыг батлан гаргасан явдал нь ихээхэн чухал ач холбогдолтой баримт бичиг болно гэж үзэж байна.

Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс Шүүхийн шүүн таслах ажлын улирлын мэдээ, анхан шатны болон захиргааны хэргийн шүүхийн мэдээ, давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн мэдээний маягт, Захиргааны хэргийн шүүхийн албан хэрэг хөтлөлтөд хэрэглэх бүртгэлийн загварыг тус тус батлав.

Мөн аймаг, нийслэл, сум болон сум дунд, дүүргийн шүүх, шүүгчийн ажил дүгнэх үзүүлэлтийг шинэчлэн баталж, Шүүгчийн сонгон шалгаруулалтын зардлыг нөхөх, түүнд зориулсан сургалт, гарын авлага гаргахтай холбогдуулж сонгон шалгаруулалтын хураамжийн хэмжээг шинэчлэв.

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн тогтоолоор “Шүүгч, шүүхийн байгууллагын ажилтнуудад тусламж олгох журмын тухай” дүрэм, “Монгол Улсын шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай журам”, “Монгол Улсын шүүхийн шагналын дүрэм”, “Шүүхийн мэргэшлийн хорооны дүрэм”-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулан баталлаа.

Түүнчлэн “Захиргааны хэргийн шүүхийн албан хэрэг хөтлөлтөд хэрэглэгдэх бүртгэлийн загвар”; “Шүүхийн шүүн таслах ажлын улирлын мэдээ”-ний Шүүхийн Статистик-3; “Анхан шатны шүүхийн захиргааны хэргийн мэдээ”-ний Шүүхийн Статистик-13; “Давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн мэдээ”-ний Шүүхийн Статистик-14 маягтуудыг тус тус батлан мөрдүүлж байна. Ийнхүү Дээд шүүх, орон нутгийн шүүх, Ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааг уялдуулахад чиглэсэн тодорхой арга хэмжээ авав.

Үүний зэрэгцээ Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын захирамжаар “Шүүгчийн өмсгөлийн хангалт, эдэлгээний хугацааны тухай журам”-д эдэлгээний хугацаа “15 жил” гэснийг “10 жил” болгон өөрчилж шүүгчдийн өмсгөлийг 2005 онд багтаан шинээр хийж өгөхөөр шийдвэрлэлээ.

Дээд шүүх 2004 оны ажлын төлөвлөгөөндөө **5** бүлэг **86** ажлыг төлөвлөснөөс **55** нь бүрэн биелэж, **7** ажил хойшлогдож, **24** ажил хагас биелэсэн байна. Тухайлбал:

Танхимын тэргүүнүүд боловсруулах учиртай “Шүүгчдийн ажил, үүргийн хуваарь, мэргэших чиглэлийн журам”, Эрүү, иргэний шүүн таслах ажиллагааны чиглэлээр баримтлах “Нэгдсэн бодлого”-ийн төсөл боовсруулах, Иргэний хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Эрүүгийн хууль, Ашигт малтмалын тухай хууль, Патентын тухай хууль, Монгол банк, Банкны тухай болон банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Зээл тооцооны үүргийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Арбитрын тухай хууль, Улс төрийн намуудын тухай болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн зарим зүйл, заалтын талаар тайлбар боловсруулан Нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах ажил тус хуралдааны бүрэлдэхүүн байхгүйн улмаас хагас биелэж; харин Нийслэл, 6 аймгийн шүүхийн ажлыг хэсэгчлэн шалгах, түүнчлэн шүүгч ажилтнуудыг “**Байгалийн үзэсгэлэнт газар**”-аар аялуулах ажил шүүгч нарын ажлын ачаалал их байснаас шалтгаалж тасалдсан.

Эдгээр ажлыг шинэ оны эхний хагаст хийж гүйцэтгэх талаар анхаарч ажиллах шаардлагатай.

Ерөнхий шүүгч **5** удаа иргэн, аж ахуйн нэгж, албан байгууллагын төлөөлөгч, нийт **41** хүнтэй биечлэн уулзаж санал хүсэлтийг нь сонсож, зохих хариуг өгсөн байна.

Шүүгчдийн зөвлөлийн хуралдааныг 2004 оны **2** дугаар сарын **13**-ны өдөр хуралдуулж Шүүгчдийн зөвлөлөөс Шүүхийн Ерөнхий зөвлөл, Шүүхийн Мэргэшлийн болон Сахилгын хорооны гишүүнээр сонгогдсон шүүгчдийн хийсэн ажлын талаархи мэдээллийг **8** дугаар сарын **6**-ны өдөр хуралдаж Захиргааны хэргийн шүүхээс Шүүхийн Ерөнхий зөвлөлд гишүүнээр сонгогдох шүүгчдийн асуудлыг тус тус хэлэлцэн шийдвэрлэв.

Шүүхийн Хэвлэл мэдээллийн алба шүүх, шүүгчийн ажиллагаатай холбоотой **91** нийтлэл гарсныг бүртгэн, Ерөнхий шүүгчид тухай бүр нь танилцуулж, мөрөөр нь холбогдох арга хэмжээг авахуулж, эдгээрээс үндэслэл муутай нийтлэлийг няцаах зорилгоор **45** хариу тайлбар, залруулгыг сонинд нийтлүүлжээ.

“**Монгол Улсын Дээд Шүүхийн Мэдээлэл**” сэтгүүлийг нийтийн хэвлэл захиалгад оруулж, уг сэтгүүлийг эрхлэн гаргах санхүүгийн эх үүсвэрийг олж, АНУ-ын “Шүүх эрх мэдлийн шинэчлэлт” төслийн дэмжлэгээр хэвлэн гаргаж бүх шатны шүүхийн шүүгчид болон бусад холбогдох байгууллагуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Мөн Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн төслийн санхүүгийн дэмжлэгээр “**Улсын Дээд шүүхийн Вэф сайт**”-ыг Интернетэд байрлуулахад бэлэн болгосноос гадна “**Улсын Дээд шүүхийн 2003 оны жилийн ажлын тайлан**”-г ном болгон хэвлүүлэв.

ХБНГУ-ын “**Ханнс–Зайделийн сан**”-ийн санхүүгийн дэмжлэг туслалцаатайгаар Аймаг, нийслэл, зарим сум дунд, дүүргийн шүүхийн **Ерөнхий шүүгчдийн Нэгдсэн зөвлөгөөн** семинарыг 2004 оны 2 дугаар сарын 12-ноос 13-ны хооронд “**Бишрэлт Плаза**” цогцолборын хурлын танхимд зохион байгуулав.

Засгийн газрын 1996 оны 287 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журам”-ын дагуу бүх шүүгчид, тамгын газрын төрийн захиргааны албан хаагчдаас “**Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэг**”-ийг 2003 оны байдлаар гаргуулан авч, шүүгчдийн “Хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг Шүүхийн Ерөнхий зөвлөлд, харин ажилтнуудын “Хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын асуудал хариуцсан референтэд өгч хадгалуулж байна.

Дээд шүүхийн эрүү, иргэний хяналтын, захиргааны давж заалдах шатны шүүн таслах ажлын мэдээ гарч, Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхим, Тамгын газар, Шүүхийн судалгааны төвийн тайлан тухайн нэгж, хамт олноороо нэгэнт хэлэлцэгдэж, Ерөнхий шүүгч түүнд биечлэн оролцсон тул Дээд шүүхийн 2004 оны **Нэгдсэн тайланг** товч танилцуулъя.

Нэг. Шүүн таслах ажлын талаар

Дээд шүүхийн \Нийт шүүгчдийн\ хуралдааныг **6** удаа зарлан, нийт **5** өдөр хуралдуулж, ирц бүрдээгүй үндэслэлээр **1** хурал хойшлогдож, бүгд **32** асуудал хэлэлцэж, тогтоол гаргасны

дотор эрүүгийн хэрэг **20**, иргэний хэрэг **3**, аймгийн шүүхийг иж бүрнээр шалган тусалсан дүнгийн тухай мэдээлэл **5**, хуулийн тайлбар **2**, “Улсын Дээд шүүхийн Нийт шүүгчдийн болон Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхимын хяналтын шатны хуралдааны дэг” батлах тухай, Захиргааны хэргийн танхим байгуулах тухай зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргав.

Өнгөрсөн жилтэй харьцуулахад Дээд шүүхийн \нийт шүүгчдийн\ хуралдаан хийсэн өдөр **7**-оор, хэлэлцсэн асуудлын тоо **4**-өөр, иргэний хэрэг **4**-өөр, аймгийн шүүхийг шалгасан ажил **6**-аар, хуулийн тайлбар **7**-оор тус тус багасаж, эрүүгийн хэрэг **9**-өөр нэмэгджээ.

1. Эрүүгийн хэргийн танхим хяналтын журмаар эрүүгийн **777**, цагаатгалын **61**, нийт **838** хэрэг хүлээн авч, түүний **97,1** хувь буюу эрүүгийн **754**, цагаатгалын **59** хэргийг хянаж шийдвэрлэжээ.

Хяналтын журмаар шүүгч Д.Батсайхан **196**, Б.Доржготов **192**, С.Нямжав **175**, М.Дамирансүрэн **134**, Танхимын тэргүүн Н.Төрбат **69** эрүүгийн хэрэг хүлээж авсан ба одоо танхимын хэмжээнд **23 хэрэгт** ажиллагаа хийгдэж байна.

Хяналтын шатны эрүүгийн шүүх хуралдаанд шүүгч Б.Доржготов **303**, С.Нямжав **291**, Д.Батсайхан **287**, М.Дамирансүрэн **278**, танхимын тэргүүн Н.Төрбат **2** удаа тус тус **оролцсоноос**;

Танхимын тэргүүн Н.Төрбат **356**, шүүгч Д.Батсайхан **124**, С.Нямжав **30** Б.Доржготов **28**, М.Дамирансүрэн **8** хэргийн шүүх хуралдааныг тус тус **даргалж**;

Шүүгч Б.Доржготов **142**, С.Нямжав **134**, Д.Батсайхан **123**, М.Дамирансүрэн **121**, танхимын тэргүүн Н.Төрбат **50** хэрэг тус тус **илтгэсэн** байна.

Эрүүгийн хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт **70** өдөр хуралдаж, **өдөрт 8-9** хэрэг хэлэлцэж, бүгд **572** хэрэг шийдвэрлэсний **96** хувь буюу **549** нь эрүүгийн, **4** хувь буюу **23** нь цагаатгалын хэрэг байв.

Дээд шүүхийн **хяналтын шатны** шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн **549** эрүүгийн хэргийн **58,4** хувь буюу **321** тогтоол, магадлалыг **хэвээр үлдээж**, **19,3** хувь буюу **106** нь **өөрчлөгдөж**, **22,2** хувь буюу **122** хэргийн тогтоол, магадлалыг **хүчингүй** болгожээ.

Өөрчлөгдсөн **106** хэргийн тогтоол, магадлалын **16,2** хувь буюу **17** нь эрүүгийн хууль буруу хэрэглэсэн, **13,2** хувь буюу **14** нь шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, **12,1** хувь буюу **13** нь хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, **3,8** хувь буюу **4** нь хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн, **54,7** хувь буюу **58** нь шийтгэх тогтоол, магадлалд бусад өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болсон **122** тогтоол, магадлалтай хэргээс **74** хэргийг прокурорт, **40** хэргийг **шүүхээр дахин хэлэлцүүлэхээр** буцааж, **9** хэргийг **хэрэгсэхгүй** болгосон байна.

Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн **23** цагаатгалын хэргээс **13** хувь буюу **3** нь овог, нэр өөрчлөх, **87** хувь буюу **47** хүнд холбогдох хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүйгээс хэрэгсэхгүй болгож цагаатгажээ.

Мөн хуралдаанаар хэлэлцэгдсэн эрүүгийн хэргээс Улаанбаатар **138**, Сэлэнгэ **21**, Дархан-Уул **17**, Өмнөговь, Төв аймгууд тус бүр **13**, Ховд **12**, Өвөрхангай **10**, Говь-Алтай, Завхан аймгууд тус бүр **9**, Увс **8**, Архангай, Булган, Дорноговь, Орхон, Хөвсгөл, Хэнтий аймгууд тус бүр **7**, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, аймгууд тус бүр **6**, Баян-Өлгий, Баянхонгор аймгууд тус бүр **5**, Сүхбаатар аймгийн **2** хэргийн тогтоол, магадлал хэвээр үлдсэн байна.

Улаанбаатар **47**, Дорноговь, Орхон, Ховд, Хэнтий аймгууд тус бүр **5**, Говьсүмбэр, Дорнод аймгууд тус бүр **4**, Дархан-уул, Сэлэнгэ, Төв аймгууд тус бүр **3**, Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Увс аймгууд тус бүр **2**, Завхан аймгийн **1** хэргийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулсан бол Баянхонгор, Хөвсгөл аймгуудын тогтоол, магадлалд өөрчлөлт оруугүй байна.

Тогтоол, магадлал нь хүчингүй болсон шүүхүүдээс Улаанбаатар **41**, Орхон, Төв аймгууд тус бүр **7**, Булган, Өвөрхангай, Увс аймгууд тус бүр **5**, Архангай, Баян-Өлгий, Дорноговь, Завхан, Ховд, Хөвсгөл аймгууд тус бүр **4**, Говьсүмбэр, Дархан-Уул, Өмнөговь аймгууд тус бүр **3**, Баянхонгор,

Говь-Алтай, Дорнод аймгууд тус бүр **2** хургийн тогтоол, магадлал хүчингүй болсон бол Дундговь, Сүхбаатар аймгуудад энэ дутагдал гараагүй байна.

Дээд шүүхийн **Нийт шүүгчдийн** хуралдаанаар эрүүгийн **20** хэрэг хэлцэгдсэний **9** нь Ерөнхий шүүгчийн дүгнэлтээр, **11** хэрэг нь цаазаар авах ялтай учир "Шүүхийн тухай" хуулийн дагуу хянагдсан байна.

Хяналтын шатны шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн **80** хувь буюу **533** нь ялтан, өмгөөлөгч, хохирогч, тэдний хууль ёсны төлөөлөгчийн гомдлоор; **16,7** хувь буюу **111** нь яллагчийн эсэргүүцлээр; **3,3** хувь буюу **20** нь прокурорын дүгнэлтээр хэлэлцэгджээ.

Нийслэл болон дүүргийн шүүхүүдийн нийт **226** хэрэг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлцэгдсэнээс **138** хэргийн тогтоол, магадлал **хэвээр** батлагдаж, **47** нь **өөрчлөлт** орж, **41** хэргийн тогтоол, магадлалыг **хүчингүй** болгосоны **22** хэргийг мөрдөн байцаалтанд, **17** хэргийг **шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт** буцааж, **3** тогтоол, магадлалыг **хүчингүй** болгож **хэргийг хэрэгсэхгүй** болгожээ.

Энэ онд шүүгч Д.Батсайхан **69**, Б.Доржготов **49**, С.Нямжав **33**, танхимын тэргүүн Н.Төрбат **21**, М.Дамирансүрэн **9** эрүүгийн хэргийг тус тус **уншиж хянаад буцаасан** байна.

Тус танхим 2004 онд нийт **247** өргөдөл, гомдол хүлээн авснаас шүүгч Б.Доржготов **91**, танхимын тэргүүн Н.Төрбат **53**, Д.Батсайхан **43**, С.Нямжав **30**, М.Дамирансүрэн **29**, өргөдлийг хянан шийдвэрлэж, одоо **1 өргөдлийн** үлдэгдэлтэй байна.

Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид хяналтын шатны **иргэний** хэргийн шүүх хуралдаанд нийт **300** удаа оролцсоноос Танхимын тэргүүн Н.Төрбат **4-г** даргалж, **36** хэрэг шийдвэрлэхэд оролцсон бөгөөд шүүгч С.Нямжав **77**, Б.Доржготов **69**, Д.Батсайхан **67**, М.Дамирансүрэн **51** удаа тус тус оролцжээ.

2. Иргэний хэргийн танхимын шүүгч нар иргэд, байгууллагаас нийт **173** өргөдөл, гомдол хүлээн авч, **163-ыг** нь буюу **94,3** хувийг шийдвэрлэжээ. Үүнд: шүүгч Ц.Амарсайхан **11**, Д.Тунгалаг **21**, А.Доржготов **61**, О.Зандраа **17**, Танхимын тэргүүн Р.Жамъянчойжил **108** өргөдөл, гомдол шийдвэрлэж, одоо **5,7** хувь буюу **10 өргөдлийн** үлдэгдэлтэй байна.

Энэ онд тус танхим **хяналтын журмаар** нийт **952** хэрэг хүлээн авч, иргэний **677** хэргийг **5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй** хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, **238** хэргийг хяналтын шүүх хуралдаанд оруулах үндэслэлгүйн учир **Ерөнхий шүүгчид** танилцуулан буцаажээ. Одоо **38** хэргийн үлдэгдэлтэй байна.

Шүүгч Ц.Амарсайхан **210** хэрэг хүлээн авч, **204-г шийдвэрлэж**, үүнээс **166** хэргийг хуралдаанд **илтгэж** шийдвэрлүүлсэн;

Шүүгч А.Доржготов **207** хэрэг хүлээн авч, **191** хэргийг **шийдвэрлэж**, үүнээс **159** хэргийг хуралдаанд **илтгэж** шийдвэрлүүлсэн;

Шүүгч Д.Тунгалаг **202** хэрэг хүлээн авч, **193-г шийдвэрлэж**, үүнээс **158** хэргийг хуралдаанд **илтгэж** шийдвэрлүүлсэн;

Шүүгч О.Зандраа иргэний **184** хэрэг хүлээн авч, **181-г шийдвэрлэж**, үүнээс **153** хэргийг хуралдаанд **илтгэж** шийдвэрлүүлсэн;

Танхимын тэргүүн Р.Жамъянчойжил **149** хэрэг хүлээн авч, **145-г шийдвэрлэж**, үүнээс **40** хэргийг хуралдаанд **илтгэж** шийдвэрлүүлсэн байна.

2004 онд Дээд шүүхийн **Иргэний хэргийн хяналтын** шатны шүүх хуралдаан **71** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **9,5** хэрэг хэлэлцэн, нийт **677** хэрэг шийдвэрлэжээ.

Танхимын тэргүүн Р.Жамъянчойжил **648** хэрэг шийдвэрлэхэд **оролцсоноос**, **608** хуралдааныг **даргалж**;

Шүүгч Д.Тунгалаг **441** хэрэг шийдвэрлэхэд **оролцсоноос**, **2** хуралдаан **даргалж**;

Шүүгч А.Доржготов **426** хэрэг шийдвэрлэхэд **оролцсоноос**, **25** хуралдаан **даргалж**;

Шүүгч О.Зандраа **414** хэрэг шийдвэрлэхэд **оролцсоноос**, **18** хуралдаан **даргалж**;

Шүүгч Ц.Амарсайхан **403** хэрэг шийдвэрлэхэд **оролцсоноос**, **11** хуралдааныг тус тус **даргалсан** байна.

Иргэний хэргийн танхимын шүүгчид хяналтын шатны **эрүүгийн** 45 өдрийн 399 шүүх хуралдаанд нийт **399** удаа оролцсоноос шүүгч **О.Зандраа 116**, Танхимын тэргүүн **Р.Жамъянчойжил 98** хуралдаанд оролцсоноос **26** хуралдааныг даргалж, шүүгч **Д.Тунгалаг 97**, **Ц.Амарсайхан 91**, **А.Доржготов 69** хэрэг шийдвэрлэхэд тус тус оролцсон байна.

Мөн шүүгч **О.Зандраа**, **Д.Тунгалаг** нар тус бүр **эрүүгийн 1** хэргийг илтгэж хяналтын шатны шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны бүрэлдэхүүнд шүүгч **А.Доржготов 8**, **Д.Тунгалаг 7** хэрэг хянан хэлэлцэхэд оролцсон байна. Тус танхим **38** хэргийн үлдэгдэлтэй ч хугацаа хэтэрсэн хэрэг байхгүй байна.

Иргэний хэргийн танхимаас 2004 онд шүүгчийн захирамж **187**-ыг гаргаснаас Гомдлыг хэлэлцэхээс татгалзах тухай **60**, Гомдлыг гаргаагүйд тооцох тухай **11**, Улсын тэмдэгтийн хураамж буцаан олгох тухай **100**, Танхимын тэргүүн **Р.Жамъянчойжил 70**, бусад шүүгчид улсын тэмдэгтийн хураамж буцааж олгох болон хэрэг хэлэлцэхээс татгалзсан **117** захирамж гаргажээ.

Улсын Дээд шүүхийн хуралдаанд хуулийн тайлбарын **1** төсөл хэлэлцүүлж батлуулжээ.

Улс төрийн намуудын тухай хуульд заасны дагуу **“Иргэний ардчилсан шинэ Либерал”** намын нэрийг **“Монголын Либерал”** нам болгон өөрчлөн бүртгэж, шинээр **“Монголын Эмэгтэйчүүдийн үндэсний нэгдсэн нам”**, **“Бүгд найрамдах намыг”** бүртгэлээ.

Ийнхүү Эрүү, Иргэний хэргийн танхимын шүүгчид тайлангийн хугацаанд өөрсдийн эрхэлсэн шүүн таслах ажлын төрлөөр өндөр ачаалалтай ажилласны зэрэгцээ шаардлагатай тохиолдолд нөгөө танхимынхаа хуралдаанд олон тоогоор, байнга оролцож, идэвх зүтгэл гаргасныг талархан тэмдэглэж байна.

3. Шинэхэн байгуулагдсан **Захиргааны хэргийн танхим** захиргааны нийт **44** хэрэг хүлээж авснаас **15**-ыг шийдвэрлэж, **29** хэргийн үлдэгдэлтэй байна.

Захиргааны хэргийн танхимын Тэргүүн **О.Зандраа** хяналтын шатны **иргэний** шүүх хуралдаанд 671 удаа **оролцсоноос 18** хуралдааныг **даргалж, 153** хэргийг **илтгэж** шийдвэрлүүлжээ.

Мөн Шүүгч **Ч.Тунгалаг 9**, **П.Цэцгээ 5** удаа оролцсон байна.

Шүүгч **Д.Пунцаг** давж заалдах шатны **захиргааны** хэргийн шүүх хуралдаанд нийт **15** удаа **оролцсоноос 11** удаа **даргалж, 4** хэрэг **илтгэж**;

Шүүгч **Ч.Тунгалаг** давж заалдах шатны **захиргааны** хэргийн шүүх хуралдаанд нийт **15** удаа **оролцсоноос 4** удаа **даргалж, 11** хэрэг **илтгэжээ**.

Захиргааны хэргийн танхим аймаг, нийслэлийн Захиргааны хэргийн шүүхүүдээс нийт **44** хэрэг хүлээж авсанаас **40** нь давж заалдах журмаар, **4** нь хяналтын журмаар гомдол гаргасан байв.

Хоёр. Шүүхийг мэргэжил, зохион байгуулалтын удирдлагаар хангах талаар

Шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах үндсэн арга зам нь хуулиудыг нэг мөр ойлгон, зөв мөрдүүлэх талаар албан ёсны тайлбар гаргах, шүүх, шүүгчдийн ажлыг шалган туслах, тэдний дунд сургалт зохион байгуулах явдал юм.

Тайлангийн хугацаанд Улсын Дээд шүүхээс **“Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58, 59 дахь заалтыг тайлбарлах тухай”, “Монгол Улсын хуульчдаас сонгох шалгаруулах тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”** зэрэг **хуулийн тайлбар 2-г** гаргасан нь эдгээр хуулийг нэг мөр зөв ойлгон хэрэглэх, шүүхийн практикийг нэгдмэл тогтооход ач холбогдлоо өгнө гэж үзэж байна.

Улсын Дээд шүүхийн Нийт шүүгчдийн хуралдаанаар **“Улсын Дээд шүүхийн Нийт шүүгчдийн болон Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхимын хяналтын шатны хуралдааны дэг”**-ийг баталсан.

Түүнчлэн малын хулгайн гэмт хэрэгт шүүхээс оногдуулж байгаа ял шийтгэлийг 2004 оны байдлаар судлан зөвлөмж боловсруулж, гаргаж, **“Үл хөдлөх эд хөрөнгийн дуудлага худалдааг**

зохицуулсан Иргэний болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн зарим зүйл заалтыг шүүхийн практикт зөв хэрэглэх тухай” зөвлөмж гаргаж, нийт шүүхүүдэд хүргүүлээ.

Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол буюу хуулийн албан ёсны тайлбарын нэмэлт, өөрчлөлтийг оруулсан **3** дахь удаагийн эмхтгэлийг хэвлүүлж, нийтийн хүртээл болгов.

Дээд шүүхийн Нийт шүүгчдийн **хуралдаанаар Баян-Өлгий, Баянхонгор, Завхан, Ховд** аймгийн шүүх, тэдгээрийн харъяа сум дундын шүүхийн ажлыг иж бүрнээр нь шалган тусалсан тухай асуудлыг хэлэлцэн **тэмдэглэл 4-ийг** гарган холбогдох шүүхүүд, Шүүхийн Ерөнхий зөвлөлд хүргүүлээ.

Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлд заасан **“Хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах”**, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 334 дүгээр зүйлд заасан **“Ялаас хугацааны өмнө суллах, эдлээгүй үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих”** тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн **“Давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагаа”**-ны талаар, **“Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийг шийдвэрлэж байгаа шүүхийн практикийн талаар”**, **“Торгуулийн ял оногдуулж байгаа байдал, түүний биелэлтийн талаар”**, Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэгт шүүхээс оногдуулж байгаа ял шийтгэлийн талаар 2003 он, 2004 оны эхний хагас жилийн байдлаар судлан **зөвлөмж**, Хээл хахуулийн гэмт хэргийн талаар улсын хэмжээнд судласан тойм, Татвартай холбоотой маргааныг шийдвэрлэж байгаа шүүхийн маргааныг судалсан **тойм зэргийг** гарган шүүхүүдэд хүргүүлээ.

Шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах, шинэ 2005 онд шүүхийн байгууллагын шийдвэрлэх зорилтыг тодорхойлж, цаашид хийх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэхэд Аймаг, нийслэл, сум, сум дунд, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч нарын жил бүрийн **“Ээлжит цугларалт, семинар”**, **“Нэгдсэн зөвлөлгөөн”** ямагт чухал ач холбогдолтой байдаг. Үүнд одооноос сайтар бэлтгэж, Аймаг, нийслэлийн болон Нийслэлийн захиргааны бүгд **23**, сум болон сум дунд, дүүргийн **38** шүүх, тэдгээрийн шүүгчдийн ажилд Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс тогтоосон ажлын үзүүлэлтээр үнэлэлт дүгнэлт өгч, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авбал зохино.

Ялангуяа шүүхийн мэргэшлийн болон сахилгын хороотой Дээд шүүх түүний танхимуудын харилцах харилцааг боловсронгуй, оновчтой болгох учиртай.

Гурав. Тамгын газрын ажлын талаар

Тамгын газар нь Шүүхийн тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль болон тэдгээртэй уялдуулан гарсан дүрэм, журам, заавар, Дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс дотоод ажил, зохион байгуулалтын удирдлагаар хангах талаар өгсөн үүрэг, даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх, танхимуудын ажиллах нөхцлийг бүрдүүлэх, нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгэх талаар анхаарч ажиллажээ.

Тамгын газрын даргын зөвлөл 10 удаа хуралдаж, уг зөвлөлийн хуралдаанаар Улсын Дээд шүүхийн 2003 оны жилийн эцсийн тооллогын дүн, тамгын газрын зарим ажилтнуудад цалинтай болон цалингүй чөлөө олгох, цалинг нь урьдчилан олгох, зарим ажилтнуудад сахилгын шийтгэл ногдуулах, эрүүл мэндийн болон амьдралын хүнд байдал, ар гэрт нь хөрөнгө мөнгөний гачигдал тохиолдсон ажилтнууд, ахмадын зөвлөлийн зарим гишүүдэд буцалтгүй тусламж олгох, эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан, ажил тасалсан зарим ажилтнуудад сахилгын шийтгэл ногдуулах зэрэг нийт **15 асуудлыг** хэлэлцэн, **Тамгын газрын даргын тушаалаар** шийдвэрлэжээ.

“Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хууль болон “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн төвшин, төрийн үйлчилгээний албан хаагчийн үр дүнгийн гэрээг үнэлж, дүгнэх журам”-д заасны дагуу Дээд шүүх дэх Төрийн захиргааны албан хаагчидтай 2003 онд байгуулсан **“Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ”**-г дүгнэхэд, 32 ажилтан хамрагдсанаас 22 нь **“А”**, 10 нь **“В”** үнэлгээ авсан нь ажилтнуудын ажиллах үр чадвар хэвийн байгааг харуулж байгаа үзүүлэлт юм.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2003 оны 84 дүгээр захирамжийн дагуу энэ оны 1 дүгээр улиралд **“Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт”**-ын улсын үзлэг улс орон даяар зохиогдоход, уг үзлэгт бэлтгэх комиссын бүрэлдэхүүн болон үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөг Тамгын газрын даргын тушаалаар батлан ажиллалаа.

Юуны өмнө шүүгчийн туслах, захиргааны бусад ажилтнуудын хэрэглэж байгаа албан баримт бичгийн стантарт, эмх цэгцэд онцгой анхаарч ажилласаны үр дүнд “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, албан хэрэг хөтлөлт”-ийн дүнгээр 81,7 оноо, “Архивын ажил”-ын дүнгээр 81,0 оноо тус тус авч, “**В буюу сайн**” үнэлэлт авлаа.

Тамгын газрын даргын 2004 оны 5, 11, 12 дугаар тушаалаар “**Улсын Дээд шүүхийн Албан хэрэг хөтлөх заавар**”, “**Архивын ажлын үндсэн заавар**”, “**Улсын Дээд шүүхийн тамга тэмдэг түших, хэвлэмэл хуудас хариуцах ажилтныг томилох тухай**”, “**Цахим хэрэгсэл, мэдээллийн сүлжээ ашиглах журам**”-ыг батлан хэрэгжүүлж байна.

Захиргааны бүх ажилтнуудад “**Баримт бичгийн стандарт**” болон ажилд нь өдөр тутам хэрэглэгдэх хууль, хуулийн тайлбар, зөвлөмж, тойм, журам зэрэг гарын авлага бэлтгэн тараан өглөө.

Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 12, 17, 18, 34 дүгээр тогтоолын “**Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх, түүгээр үйлчлэх журам**”, “**Төрийн албан хаагчийн тоо бүртгэл хөтлөх журам**”, “**Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам**”, “**Ажлын байрны тодорхойлолтын загвар**”, “**Ажлын байрны тодорхойлолт боловсруулах заавар**”-ын хавсралтаар батлагдсан маягтуудыг Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын асуудал хариуцсан референтын компьютерт шинээр суулгуулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж эхэллээ.

Клинкийн Нэгдсэн 2 дугаар эмнэлэг болон Төрийн Тусгай албан хаагчдын Нэгдсэн эмнэлэгээр 2004 онд үйлчлүүлэх шүүгч, ажилтнууд, тэдний эхнэр, нөхөр, ам бүлд байгаа хүүхдүүдийн судалгааг хавсралтаар гарган **дээрхи эмнэлгүүдийн захиргаанд** хүргүүлж, тэднийг байнгын эмчийн хяналт, эмнэлгийн урьдчилсан үзлэгт хамруулах, шаардлагатай тохиолдолд хэвтэн эмчлүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлж өглөө.

Түүнчлэн “**Монгол Улсын Утасны лавлах ном**” шинэчлэгдэн хэвлэгдэх болсонтой холбогдуулан Улсын Дээд шүүхийн шүүгч, ажилтнуудын утасны жагсаалтыг хавсралтаар гарган хүргүүлж, уг номонд оруулж иргэдээс шүүхэд хандах боломжийг нэмэгдүүлэв..

Шүүгч, ажилтнуудын гэр бүлээс их, дээд сургуульд 2004-2005 оны хичээлийн жилд суралцаж байгаа **4** оюутны нэрсийн жагсаалтыг Тамгын газрын даргын 2004 оны 69 дүгээр тушаалын хавсралтаар батлуулан, тэдний “Сургалтын төлбөрийг төрөөс хариуцан санхүүжүүлэх тухай” гэрээг Сургалтын төрийн сантай байгууллаа.

Байгууллагын Номын санд **43** нэрийн **104** ширхэг ном шинээр бүртгэсэний **17** нэрийн **43** ширхэг номыг “Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг”, “Соросын сан”, “Ханнс-Зайдалын сан”, “Хүний Эрхийн Үндэсний төв”, “Албадан ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагааг хэвшүүлэх” төслөөс тус тус бэлэглэлийн журмаар өгсөн байна.

Түүнээс гадна **52** ширхэг номыг **160600** төгрөгөөр худалдан авсаны дотор Эрүүгийн эрх зүйн **22**, Иргэний эрх зүйн **19**, Захиргааны эрх зүйн **35**, Үндсэн хуулийн эрх зүйн **7**, Монголын түүхийн **5** боть болон бусад **16** ширхэг номыг ашиглаж байна.

Дэлхийн банкны санхүүжилттэй “Шүүх, эрх зүйн шинэчлэл” төсөлтэй хамтран Ерөнхий шүүгчийн албан болон уулзалтын өрөө, Эрүү, Иргэний хэргийн танхимуудын тэргүүн, Тамгын газрын дарга, Захиргааны хэргийн танхимын тэргүүн, шүүгчид, шүүгчийн туслахуудын өрөөний **56,677,9** мянган төгрөгийн тавилга; Иргэний болон Захиргааны хэргийн танхимын давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдааны танхимын **24,003,6** мянган төгрөгийн тавилга болон **33.158,0** мянган төгрөгийн иж бүрэн компьютер, **155,7** мянган төгрөгийн утасны аппарат, **1,742,6** мянган төгрөгийн зурагт, **147,1** мянган төгрөгийн **DVD** уншигч, **129,3** мянган төгрөгийн приставк нийт **116,014,2** төгрөгийн эд хөрөнгийг Дээд Шүүхийн ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор шинээр авсан.

Төрийн албаны тухай хуульд заасны дагуу ээлжийн амралтаараа өөрийн төрсөн нутаг очиж амарсан **5** шүүгч, ажилтанд очих, ирэх унааны зардал **124,5** мянган төгрөгийн тусламж, хамт олны дотроос ар гэрт нь гачигдал тохиолдсон **15** шүүгч, ажилтан, Ахмадын зөвлөлийн зарим гишүүн, өндөр настнуудад нийт **760,0** мянган төгрөгийн буцалтгүй тусламжийг Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн Тамгын газрын даргын тушаалаар олгов.

Улсын Дээд шүүх, Нийслэл, дүүрэг, Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн “Шилжин явах цом”-ын төлөө спортын тэмцээнийг зохион байгуулахад манай баг, тамирчид амжилттай оролцож, багийн нийлбэр дүнгээр **тэргүүн** байр эзэлж, “Шилжин явах цом”, “Алтан медаль” хүртлээ.

Түүнчлэн хуулийн төв байгууллагуудын дунд жил бүр уламжлал болон зохиогддог “Шилжин явах цомын төлөө спортын тэмцээн”-ийг энэ жил Монголын Өмгөөлөгчдийн Холбооноос зохион явуулахад манай баг тамирчид амжилттай оролцож, багуудын нийлбэр дүнгээр **3 дугаар** байр эзлэв.

Улсын Дээд шүүхийн **2004** оны батлагдсан төсөв **196.968.1** мянган төгрөг байснаас **14,0** сая төгрөг нь тоног төхөөрөмжийн, **6,0** сая төгрөг нь их засварын зардалд зориулагдсан хөрөнгө оруулалтын төсөв байлаа.

Батлагдсан хөрөнгө оруулалтын төсөв дээр нэмж **35.0** сая төгрөг тусгуулан тоног төхөөрөмжийн зардалд, **49.0** сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнийг бүрэн авч, зохих зориулалтын дагуу зарцуулсан.

Урсгал зардлын батлагдсан төсвийг бүрэн авч зохих журмын дагуу зарцуулж, санхүүгийн мэдээ тайланг хугацаанд нь гаргаж ирлээ.

Урсгал зардлын төсвийг хэрхэн зарцуулсныг зүйл тус бүрээр нь танилцуулбал:

- Бичиг хэрэг, аж ахуйн зардалд **6.279.5** мянган төгрөг төлөвлөснөөс **6.788.7** мянган төгрөг зарцуулсан бөгөөд **509.2** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Гэрэл цахилгааны зардалд **2.667.6** мянган төгрөг төлөвлөснөөс **3.023.3** мянган төгрөг зарцуулж, **355.7** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Түлш, халаалтын зардалд **13.242.7** мянган төгрөг төлөвлөснөөс **11.013.9** мянган төгрөг зарцуулж, **2.228.8** мянган төгрөг **хэмнэсэн**;
- Тээвэр, шатахууны зардалд **6.575.3** мянган төгрөг төлөвлөснөөс **7.109.0** мянган төгрөг зарцуулж, **5337** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Шуудан, холбооны зардалд **13.159.0** мянган төгрөг төлөвлөснөөс **10.149.1** мянган төгрөг зарцуулж, **3.009.9** мянган төгрөг **хэмнэсэн**;
- Цэвэр, бохир усны зардалд **984.0** мянган төгрөг төлөвлөснөөс **219.4** мянган төгрөг зарцуулж, **764.6** мянган төгрөг **хэмнэгдсэн**;
- Дотоод албан томилолтын зардалд **2.918.0** мянган төгрөг төлөвлөснөөс **1.814.0** мянган төгрөг зарцуулж, **1.104.0** мянган төгрөг **хэмнэгдсэн**;
- Ном, хэвлэл авах зардалд **1.011.6** мянган төгрөг төлөвлөснөөс **582.6** мянган төгрөг зарцуулж, **429.0** мянган төгрөг **хэмнэгдсэн**;
- Нормын хувцас авах зардалд **127.5** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **127.5** мянган төгрөг зарцуулагдсан;
- Урсгал засварын зардалд **1.833.3** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **1.795.0** мянган төгрөг зарцуулж, **38.3** мянган төгрөг **хэмнэгдсэн**;
- Гадаад зочны зардалд **5.100.0** мянган төгрөг төлөвлөснөөс **5.100.0** мянган төгрөг зарцуулагдсан;
- Ерөнхий шүүгчийн байрны зардалд **303.2** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **286.8** мянган төгрөг зарцуулж, **16.4** мянган төгрөг **хэмнэгдсэн**;
- Буцалтгүй тусламж, тэтгэлэг урамшууллын зардалд **6.025.7** мянган төгрөг төлөвлөснөөс **6.700.6** мянган төгрөг зарцуулж, **674.9** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Төлбөр хураамж болон бусад зардалд **1006.3** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **1.006.3** мянган төгрөг зарцуулагдсан;
- Бараа үйлчилгээний бусад зардалд **61.528.0** мянган төгрөг төлөвлөснөөс **85.115.7** мянган төгрөг зарцуулж, **23.587.7** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд **27.029.6** мянган төгрөг төлөвлөснөөс **24.159.5** мянган төгрөг зарцуулж, **2.870.1** мянган төгрөг **хэмнэгдсэн**;
- Цалин хөлс, нэмэгдлийн зардалд **102.384.8** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **87.692.9** мянган төгрөг зарцуулж, **14.691.9** мянган төгрөг **хэмнэгдсэн** байдалтай байна.

2004 онд шүүгч, ажилтнуудынхаа ая тухтай ажиллах нөхцлийг сайжруулах, тэдний **нийгмийн асуудлыг** шийдвэрлэх, зарим хүмүүсийг **шагнаж урамшуулах**, байгууллагын **тохижилт, засвар, үйлчилгээ**, бичиг **хэргийн зардал** болон бусад зардалд нийт **26,1** сая

төгрөгийг зарцуулсан байна. Түүнчлэн дээр дурдсан Дэлхийн банкны төслийн хөрөнгөнөөс 116 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийв.

Энэ тухай мэдээлэл Тамгын газрын тайланд маш тодорхой байгаа болно.

Түүнчлэн тайлангийн энэ онд нийт **түрээсийн орлого** болох **8606,0** мянган төгрөгнөөс төсвийн зардал мөнгө хүрэлцдэггүй бусад арга хэмжээнүүдэд зарцуулж, одоо **1880,0** сая төгрөг үлдсэнийг байгууллагын **Шинэ жилийн арга хэмжээнд** зарцуулна.

Түрээсийн орлогыг хэрхэн зарцуулсан талаархи мэдээллийг Тамгын газрын тайлангаас тодорхой үзээрэй.

Төрийн албаны тухай хуульд заасны дагуу ээлжийн амралтаараа өөрийн төрсөн нутагт очиж амарсан **5** шүүгч, ажилтанд очих, ирэх унааны зардал **124,5** мянган төгрөгийн тусламж, хамт олны дотроос ар гэрт нь гачигдал тохиолдсон **15** шүүгч, ажилтан, Ахмадын зөвлөлийн зарим гишүүн, өндөр настнуудад нийт **760,0** мянган төгрөгийн буцалтгүй тусламжийг Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн Тамгын газрын даргын тушаалаар олголоо.

Ийнхүү 2004 онд байгууллагаа тохижуулах, шүүгч, ажилтнуудын ая тухтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх, техникжүүлж, компьютержүүлэхэд ихээхэн анхаарч ажиллав.

Улсын Дээд шүүхэд Захиргааны хэргийн танхим байгуулагдах болсонтой холбогдуулан тус танхимын шүүгч, шүүгчийн туслахуудын суух өрөөг зайлшгүй засварлах шаардлагатай байсан тул уг ажлыг хийж гүйцэтгэх гүйцэтгэгчийг Дэлхийн банкны санхүүжилтэйгээр “Шүүх эрх зүйн шинэчлэл” төсөл сонгон шалгаруулж, “Дэлгэр Интернетейшнл” ХХК-аар 3 дугаар давхарын их засварын ажлыг хийлгэж дуусгалаа.

Түүнчлэн улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх **6.0** сая төгрөгийн өртөгтэй засварын ажлыг “Монгол дээвэр” ХХК-аар, мөн уг компаниар 1 дүгээр давхрын 4 өрөө, 2 дугаар давхрын 2 өрөө, 3 дугаар давхрын 5 өрөө, 4 дүгээр давхрын 10 өрөө, 3 дугаар давхарын бестбюль зэргийг засварлуулан хийлгэж, үүнд дутсан зардал **2,0** төгрөгийг түрээсийн орлогоос гаргасан.

Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргын 2004 оны 75 дугаар тушаалаар байгуулагдсан **тооллогын комисс** нь **14** хоногийн хугацаанд байгууллагын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг шүүгч, ажилтнуудын эзэмшиж байгаа эд хөрөнгө, шүүх хуралдааны танхим, коридор, бестбюльд байгаа эд зүйлсийг хариуцсан үйлчлэгчдийн карттай нь, агуулахад хадгалагдаж байгаа эд зүйлсийг үлдэгдлээр нь менежер–нягтлан бодогчын бүртгэлтэй тулган тоолсон байна.

Байгууллагын дүнгээр **342,422,3** мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө, **6,179,5** мянган төгрөгийн үнэ бүхий бичиг хэрэг, аж ахуйн материал, **121,001,0** мянган төгрөгийн үнэ бүхий бүхий **5** автомашин тоологдлоо.

Дөрөв.Шүүх судлалын төвийн ажлын талаар

Дээд шүүхийн дэргэдэх шүүхийн судалгааны төв нь Шүүхийн тухай хуулийн 72 дугаар зүйл, Шүүхийн Судалгааны төвийн дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, Дээд шүүхийн 2004 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажил болон Дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс өгсөн үүрэг даалгаврыг ханган биелүүлэхэд өөрийн үйл ажиллагааг чиглүүлэн ажиллажээ.

2004 онд батлагдан гарсан Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, Үндсэн хуулийн Цэцийн тогтоол, Төрийн мэдээлэл сэтгүүлүүдийг дугаар бүрээр хүлээн авч шүүгч, ажилтнуудад бүрэн эхийг хувиалан олгосноос гадна дотоод сүлжээнд оруулав. Үүнд:

- Монгол Улсын хуулиуд;
- Улсын Их хурал, Үндсэн Хуулийн Цэц, Засгийн газрын тогтоолууд;
- Монгол Улсын Дээд шүүхийн хууль тайлбарласан тогтоол;
- Үндсэн хуультай зөрчилдсэн бусад хуулийн заалтыг хүчингүй болгосон Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт;
- Шүүн таслах ажлын практик ач холбогдол бүхий хяналтын шатны эрүү, иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоол;

- Эрүү, иргэний хэргийн танхимуудаас гаргасан зөвлөмж;
- Шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах зорилгоор гаргасан Ерөнхий шүүгчийн захирамж, холбогдох эрх бүхий байгууллагуудын хамтарсан захирамж, тушаал;
- Холбогдох эрх бүхий байгууллагуудтай хамтран гаргасан тушаал;
- Нийслэл болон орон нутгийн шүүхүүдийн ажлыг шалган тусалсан дүн зэргийг “Нэгдсэн сан”-д оруулсан.

2004 онд “Нэгдсэн сан”-д оруулахаар **78** хуулийг хүлээн авснаас **15** хууль нь бүхэлдээ шинээр батлагдсан, **63**-д нь нэмэлт өөрчлөлт орсныг байгууллагын мэдлэгийн санд хуулийн эх хувь болон Төрийн мэдээлэл сэтгүүлийн байгууллага дахь хувьд тухай бүрт нь хайчилбараар өөрчлөлт хийж, компьютерийн дотоод сүлжээн дахь хууль тогтоомжийн лавлагаанд зохих өөрчлөлтийг давхар оруулав.

Монгол Улсын Дээд шүүхийн хууль тайлбарласан тогтоолуудын жагсаалтыг 1959 оноос 2004 он хүртэл эрүү, иргэн, бусад хуулийн тайлбарууд гэсэн ангилалаар гаргаж тэдгээрийн хүчингүй болсон бусад, өөрчлөлт орсон заалтуудыг системчлэх ажлыг хийлээ.

Улсын Дээд шүүхээс эрхлэн хэвлүүлсэн “Дээд шүүхийн тайлбар, тогтоолын эмхтгэл” номыг хэвлэлд бэлтгэн 1150 ширхэгийг хэвлүүлснээс 700 гаруй ширхэгийг зарж борлуулан нийтийн хүртээл болгож, “Монголын төр ,эрх зүй” сэтгүүлийг Дээд шүүхийн мэдээлэл сэтгүүлд нийтлэх материалыг бэлтгэн 4 дугаарыг гаргаж нийтийн захиалгаар болон шүүгч, ажилтнууд, санхүүжүүлэгч байгууллагуудад түгээв.

Мөн “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр”-өөс санхүүжүүлсэн компьютерийн “SPSS 9.0” программ дээр ажиллах сургалтад С.Эрдэнэчимэг, Х.Батбаатар нарыг; “Хүний эрхийн үндэсний комисс”-оос зохион байгуулсан “Баривчлах, цагдан хорих, зөвшөөрөл олгоход хүний эрхийг хангах нь” сэдэвт сургалтанд болон АНУ-ын “Барын” холбооноос зохион байгуулсан “Мөнгө угаах болон санхүүгийн гэмт хэргийг мөрдөн байцаах арга” сэдэвт семинарт С.Одгариг нарыг хамрууллаа. ХБНГУ-ын “Ханнс-Зайделийн сан”-гаас зохион байгуулсан “Үндсэн хуулийн цэц ба Захиргааны хэргийн шүүх” сэдэвт Олон улсын симпозиумд Судалгааны төвийн захирал П.Цэцгээ оролцсон.

Тус судалгааны төв нь Захиргааны хэргийн шүүх байгуулагдсантай холбоотойгоор уг шүүхийн шүүн таслах ажлын дүнг гаргахад чиглэсэн 3 төрлийн мэдээний маягтыг, мэдээ гаргах зааврын хамт боловсруулж, шүүхүүд болон Үндэсний Статистикийн газраас санал аван тусгаж, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Үндэсний Статистикийн газрын хуралдаанд оруулан батлуулжээ.

Тав. Гадаад арга хэмжээ, сургалт, семинарын талаар

Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, шүүгчийн туслахууд болон Тамгын газрын ажилтнууд 2004 онд гадаад болон дотоодод болсон сургалт, семинаруудад идэвхтэй оролцлоо.

Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ч.Ганбат “Үндсэн Хуулийн Цэц болон Захиргааны хэргийн шүүхийн тулгамдсан асуудал” Олон Улсын симпозиумд “Монгол Улсад Захиргааны хэргийн шүүх байгуулагдаж буй үйл явц, түүний онцлог” сэдвээр илтгэл тавьсан.

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн О.Зандраа, Тамгын газрын дарга Д.Эрдэнэчулуун Нийслэлийн шүүхийн тамгын хэлтсийн дарга Н.Дагва нарын 3 хүн “Шүүх эрх мэдлийн шинэтгэл хөтөлбөр” төслийн шугамаар АНУ-ын Вашингтон хотод “**Шүүхийн менежмент**” сэдэвт **сургалтанд**, Дээд шүүхийн шүүгч С.Нямжав, Нийслэлийн шүүхийн шүүгч Л.Бямбаа, Баянзүрх дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч Ё.Цогтзандан, Баянгол дүүргийн шүүхийн шүүгч Х.Алтанцэцэг, Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч Ч.Тунгалаг, Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгч Д.Даваасүрэн, Хан-Уул дүүргийн шүүхийн шүүгч Х.Батбаяр, Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгч Ж.Цэнгэл нарын 8 хүн, **АНУ**-ын Техас муж улсын Уэслианы Их сургуулийн Хуулийн Их сургууль дээр зохиогдсон **сургалтанд**, Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн туслахаар ажиллаж байсан Ц.Цогт болон аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч нарын нийт 14 хүн **БНСУ**-ын Дээд шүүхийн дэргэдэх шүүгчдийн сургалтын төвд 14 хоногийн сургалтад оролцов.

Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ч.Ганбат, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч Д.Дамдиндорж, Захиргааны хэргийн танхимын тэргүүн О.Зандраа, шүүгч П.Цэцгээ нарын 4 хүн ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн урилгаар **ХБНГУ-ын Бавари** муж улсын **Захиргааны** хэргийн шүүхийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлав

ХБНГУ-ын Техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг, Дээд шүүхийн тохиролцооны дагуу Бавари муж улсад болон Шүүгч багш бэлтгэх 45 хоногийн сургалтад Нийслэлийн шүүхийн шүүгч Ундрах, Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгч Золзаяа, Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгч Буд нар оролцов.

Түүнчлэн Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ч.Ганбат Мексик Улсын Валли де Браво хотноо зохион байгуулагдсан “Олон Улсын шүүгчдийн холбооны 17 дугаар бага хурал”-д оролцов.

Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгч Ц.Цогт Энэтхэг улсын Дели, Лакнау хотуудад зохион байгуулагдсан “Олон Улсын Ерөнхий шүүгч нарын 5 дугаар чуулга уулзалт”-д Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн даалгавараар оролцлоо.

Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн дарга Ч.Ганбатын урилгаар БНСУ-ын Ерөнхий шүүгч Жонг Ёнг Чой тэргүүтэй төлөөлөгчид манай оронд **албан ёсны айлчлал** хийж, Улсын Дээд шүүх болон Өмнөговь аймгийн шүүхийн ажил байдалтай танилцав. ОХУ-ын Буриад Улсын Дээд шүүхийн дарга А.О.Хориноев тэргүүтэй төлөөлөгчид Улсын Дээд шүүх, Нийслэл, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймгийн шүүхийн ажилтай танилцсан.

Мөн Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ч.Ганбатын урилгаар АНУ-ын Техас муж улсын Уэслианы Их сургуулийн профессор, Азийн дээд сургуулийн захирал, ноён Жое Спурлок II манай оронд айлчилж, Улсын Дээд шүүх, Нийслэл, Нийслэлийн захиргааны хэргийн болон Дархан-Уул, Орхон, Өмнөговь аймгийн шүүхийн шүүгчидтэй уулзан, эдгээр шүүхүүдийн ажил байдалтай танилцлаа.

Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ч.Ганбат АНУ-ын Муж улсуудын шүүхийн үндэсний төвийн Зөвлөлийн дарга, Висконсон муж улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, ноён Ширлэй Абрахамсоныг, “Ханнс-Зайдель”-ийн сангийн шугмаар манай оронд айлчилж байгаа ХБНГУ-ын Бавари муж улсын Захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч Р.Хюффер, ХБНГУ-ын Холбооны Үндсэн Хуулийн шүүхийн шүүгч Мерлингхоф, Нидерланд Улсын Амстердам хотын шүүгч Брок Ховенг, Дэлхийн Банкны “Шүүхийн эрх зүйн шинэтгэл” төслийн удирдагч Мариана Монтиел, Дэлхийн Банкны ажилтан Росио Малпика нарыг хүлээн авч уулзлаа.

Ирж буй 2005 онд Монголын **8** шүүгч АНУ-ын **Техас** муж улсын Уэслины Их сургуульд болох уламжлалт сургалтад; Захиргааны шүүхийн шүүгчид ХБНГУ-ын “Ханнс Зайдел”-ийн сангийн шугамаар Бади муж улс дахь захиргааны шүүгчдийн сургалтад; бусад ердийн шүүхийн шүүгчид БНСУ-ын Дээд шүүхийн дэргэдэх шүүгчдийн сургалтын төв хийгдэх сургалтад тус тус оролцох болно.

Эрхэм шүүгч, ажилтнуудаа!

Тайлангийн хугацаанд бусдаасаа илүү идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан Иргэний хэргийн танхимын тэргүүн Р.Жамьянчойжил, шүүгч Д.Батсайхан, С.Нямжав, Д.Тунгалаг, Хангамжийн асуудал хариуцсан менежер С.Баасанцэрэн, Цагаатгалын ажил хариуцсан шинжээч Н.Чойням, компьютерийн техник хангамжийн ажил хариуцсан мэргэжилтэн Д.Мөнхзориг, Ерөнхий шүүгчийн туслах Б.Цогт, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч М.Алдар, Б.Зориг, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч Г.Буяннэмэх, Архив, номын сан хариуцсан мэргэжилтэн Ж.Тэгшдэлгэр, жолооч Б.Пүрэв, Г.Батчулуун, сантехникийн слесарь бөгөөд цахилгаанчин Б.Ширэндэв, үйлчлэгч Л.Даваажав, Д.Оюунцэцэг нарт хамт олныхоо нэрийн өмнөөс болон хувиасаа гүн талархал илэрхийлж, цаашдын ажил хөдөлмөрт нь өндөр амжилт хүсэн ерөөе!

Эрхэм шүүгчид, албан хаагчид аа!

Улирч буй 2004 онд бид багагүй зүйл хийж амжуулсан ч шинэ 2005 онд түүнээс ч их зүйл хийх шаардлагатай байна.

Улсын Дээд шүүх, Шүүхийн байгууллагын өмнө 2005 онд дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

Нэгдүгээрт: Нийтлэг зорилтууд

1.Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай болон Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, бусад хуулиудыг хэрэгжүүлэх явдлыг шүүх, шүүгчийн үйл ажиллагааны **үндсэн дээд зарчим** болгон ажиллаж, хууль зөрчсөн тохиолдол бүрт зохих үнэлэлт дүгнэлт өгч, шаардлагатай тохиолдолд шүүхийн Мэргэшлийн хорооны дүгнэлт гаргуулах, шүүхийн Сахилгын хороонд шилжүүлэн шалгуулах арга хэмжээг авч ажиллах;

2.Монгол Улсын Их хурал 1998 онд баталсан **“Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”**, 2000 онд баталсан **“Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”**-г хэрэгжүүлэх, Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2003 онд болсон **“Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдах ажилтны Нэгдсэн зөвлөлгөөн”**-ий шийдвэрийг биелүүлэх, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн хуралдаанаар 2004 онд баталсан **“Шүүхийн менежментийг боловсронгуй болгох үзэл баримтлал”**-ыг ажил хэрэг болгох замаар Монголын **шүүхийн шинэчлэлийг улам гүнзгийрүүлж, эрчимжүүлэх;**

3.Шүүхийн шинэчлэлийн үйл ажиллагаанд АНУ-ын **“Шүүх эрх мэдлийн шинэтгэл хөтөлбөр”**, ХБНГУ-ын **“Ханнс-Зайдел”-ийн сан**, түүний **“Эрх зүйн боловсрол академи”**, **“Германы Техникийн Хамтын Ажиллагааны нийгэмлэг”**, Дэлхийн банкны **“Шүүх эрх зүйн шинэтгэл”** төслийн онол, арга зүй, санхүүгийн тал бүрийн дэмжлэгийг үргэлжлүүлэн авч ажиллахын гадна Японы **“Жайка”**, БНСУ-ын **“Койка”**, **“Олон Улсын Шүүгчдийн холбоо”** зэрэг олон улсын байгууллагуудтай үйл ажиллагаагаа бэхжүүлэн ажиллах;

Шүүхийг шинэчлэх ажиллагаанд өөрийн орны иргэд, эрдэмтэн судлаачид, төр засгийн байгууллага, албан тушаалтнууд, хэвлэл мэдээллийн байгууллагын санал, зөвлөгөө, шүүмжлэл, дэмжлэгийг өргөн авч ажиллах;

Хоёрдугаарт: Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхим /Н.Төрбат, Р.Жамъянчойжил, О.Зандраа/-д дараах ажлыг хийж гүйцэтгэхийг үүрэг болгож байна.

1. Эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд баримтлах **“Нэгдсэн бодлого”**-ыг 2004 оны шүүн таслах ажлын үр дүнтэй холбогдуулан илүү оновчтой боловсронгуй болгох, **захиргааны хэргийг** шүүн таслах ажиллагаанд баримтлах **“Нэгдсэн бодлого”**-ыг Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.3-т заасан дагуу боловсруулж, Дээд шүүхийн **Нийт шүүгчдийн** хуралдаанаар батлуулж мөрдүүлэн, эрхэлсэн шүүн ажиллагааны шүүн төрөлдөө чанарын мэдэгдэхүйц ахиц гаргаж ажиллах;

2. **Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн** давж заалдах, хяналтын шатны шүүх хуралдаанаас гарсан **шийдвэрийг хэвлэн нийтэлж**, нийтийн хүртээл болгох, шүүн таслах ажиллагааг иргэд, судлаачдын хяналтад **ил тод** болгох. Үүний тулд Дээд шүүх болон танхимын давж заалдах, хяналтын хуралдаанаас гарч байгаа **магадлал, тогтоолын хууль зүйн үндэслэл, бүтэц, найрлагыг** боловсронгуй болгож, түүнийг **хэвлэн нийтлэх журам, арга зүй, системчлэлийг** боловсруулж мөрдүүлэх;

3. **Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн** шүүн таслах ажиллагааны 2004 оны дүн мэдээ, тайланд үнэлэлт, дүгнэлт өгч, шүүхүүдэд өгөх мэргэжлийн удирдамж, **зөвлөмжийг** боловсруулан гаргаж, 2005 оны 1 дүгээр сарын сүүлч 2 дугаар сарын эхээр болох **“Нийт шүүхийн Ерөнхий шүүгч нарын Нэгдсэн зөвлөлгөөн”**-д сайтар бэлтгэж, шүүхүүдийг **мэргэжлийн удирдлагаар** хангах ажлыг оновчтой, шуурхай зохион байгуулж ажиллах;

4. **Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн** анхан шат, давж заалдах болон хяналтын шатны **статистик мэдээ, тайланг бичгээр гаргах**, түүнийг **компьютерийн программд оруулах, нэгдсэн сүлжээнд холбох**, бүх шатны шүүхийн шүүгчдийн болон танхимуудын ажлын **ачааллыг цаашид тэнцвэржүүлэх, шүүхийн байршил, орон тоог** зохистой тогтоох, шүүн таслах ажиллагааны **менежментийг цаашид боловсронгуй болгох** талаар өөрсдийн саналыг боловсруулж Дээд шүүхийн болон Шүүхийн Ерөнхий зөвлөлийн хуралдаанд оруулан шийдвэрлүүлж байх;

Эдгээр ажлыг хэрэгжүүлэхэд Дээд шүүх, Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс танхимуудад бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлж байх болно.

Гуравдугаарт: Тамгын газар /Д.Эрдэнэчулуун/-д үүрэг болгох нь:

1. Аймаг, нийслэл, дүүргийн шүүхийг Дээд шүүхтэй **компьютерийн нэгдсэн сүлжээнд** холбох ажлыг хийж гүйцэтгэх. Үүнд шаардлагатай техник хэрэгсэл, хөрөнгө, ажиллах хүчний тооцоог гаргаж, ойрын хугацаанд танилцуулах;

2. **Эрүү, Иргэний** хэргийн **танхимын шүүгчдийн албан өрөөг** Захиргааны хэргийн танхимын шүүгчидтэй ижил түвшинд тохижуулах, Захиргааны хэргийн танхимыг унаагаар хангах, Дээд шүүхийн албан байрны **давхруудын нийтийн талбайг** тохижуулах. Шүүгч ажилтнуудын албан ажлын ажиллаж бага оврийн автобусыг шинэчлэх. Энэ бүхэнд шаардлагатай хөрөнгийн тооцоог гаргаж Ерөнхий шүүгч, Ерөнхий зөвлөлийн даргаас өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу ажиллах;

3. Дээд шүүхийн 2004 оны ажлыг дүгнэсэн **Нэгдсэн зөвлөлгөөн**, Танхимууд. Судалгааны төвийн зөвлөлгөөн дээр шүүгч, ажилтнуудаас тавьсан **санал, шүүмжлэл**, хүсэлтийг тусгасан 2005 онд Дээд шүүхээс хийж гүйцэтгэх ажлын **төлөвлөгөөний** төслийг боловсруулан ойрын хугацаанд Ерөнхий шүүгчид танилцуулж, батлуулан, хэрэгжүүлэх;

4. **Шүүхийн Судалгааны төвийн** дутуу орон тоог бүрдүүлэх талаар саналаа танилцуулан шийдвэрлүүлж, тус төвийн үйл ажиллагааг жигдрүүлэн сайжруулах шаардлагатай байна.

Энэ бүх зорилтыг шийдвэрлэхийн төлөө хамтран ажиллацгаая.

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА.